



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/66

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.1 Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Сумын 2023 оны төсөвт нэмэлт зохицуулалт хийх тухай” 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд үрээр мод тариалах, суулгац бэлгэх, худалдан авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

- | | |
|----------------------|--|
| Ажлын хэсгийн дарга: | Ч.Сугармаа
(Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч) |
| Гишүүд: | М.Мөнхзаяа
(Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн) |
| | Б.Алтансүх
(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн) |

2.Сумын 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих арга хэмжээ”-ний хүрээнд үрээр мод тариалах, суулгац бэлтгэх, худалдан авах ажилд 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийг зарцуулсугай.

3.Тус арга хэмжээнд зарцуулагдах 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн “Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих арга хэмжээ”-нд зарцуулахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

4.Дээрх ажлыг чанартай гүйцэтгэж тайлагнахыг ажлын хэсгийн дарга Ч.Сугармаа, хэрэгжилтийг хянан мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (О.Отгонбаяр), захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавиж ажиллахыг Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (М.Гантуяа) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ